

“Эрдэнэст” ХХК, “Аргай бэст” ХХК-д брокер,  
дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5 дахь, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтууд болон “Эрдэнэст” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр, “Аргай бэст” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2003 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэст” ХХК, “Аргай бэст” ХХК-д үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Эрдэнэст” ХХК болон “Аргай бэст” ХХК-ийн гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд сурталчлан ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ